| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,912,686.55 | 4,028,696.37 | 116,009.82 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | <u>3,914,365.45</u> | <u>4,066,851.05</u> | <u>152,485.60</u> |

Мөнгөн хөрөнгө данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Оны эхний 0.9 сая төгрөгийн авлагыг барагдуулж, ХХОАТ-т шинээр 3.8 сая төгрөгийн авлага үүсгэж ажилласан байна.

Бараа материалын дансны оны эхний, эцсийн үлдэгдэл 98.4 сая төгрөг ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 28.4 сая төгрөгийн бараа материал худалдан авсныг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,964.7 сая төгрөг болж оны эхнээс 149.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 79.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Орон нутгийн хөгжлийн сангаас 227.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Засгийн газрын оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 116.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 696.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагын 2024 оны анх батлагдсан төсөв 1,001.3 сая төгрөг байна. Үүнд: Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,001.3 сая төгрөгөөр баталсан байна.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд тус байгууллагын батлагдсан төсвийг 99.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,100.8 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Анх батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 48.1 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6.0 сая, хангамж, бараа материалын зардлыг 5.0 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 10.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 15.3 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 15.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 1,091.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 991.5 сая төгрөгийн санхүүжилт авч, зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,035.7 сая төгрөг буюу 94 хувьтай байна. Энэ нь орон нутгийн төсвөөс 65.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | /мянган төгрөгөөр/ | | Биелэлт |
|---|---|--------------------|--------------------|------------------|------------|
| | | | Гүйцэтгэл | Зөрүү | |
| ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага | | | | | |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 756,687.8 | 734,238.8 | -22,449.0 | 97% |
| 2 | Туслах үйл ажиллагааны зардал | 169,414.9 | 153,478.0 | -15,936.9 | 91% |
| 3 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 46,933.0 | 43,213.6 | -3,719.4 | 92% |
| 4 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 9,500.0 | 7,950.3 | -1,549.8 | 84% |
| 5 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 118,249.0 | 96,807.6 | -21,441.4 | 82% |
| | Дүн | 1,100,784.7 | 1,035,688.2 | -65,096.5 | 94% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 17.1 сая нэмэлт санхүүжилт авсан. Үүнээс 5.3 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 11.8 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд батлагдсан төсвийн хүрээнд 28.4 сая төгрөгийн бараа материал, 79.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 89 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 821.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 16.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 38 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгахад сумын Засаг даргын захирамжаар засаг даргын зөвлөхийн орон тоо бий болгож, төсвөөс цалингийн зардалд 2.5 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрч зөвлөмж өгсөн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансанд байршуулах өр үүсгэсэн 38.2 сая төгрөгийн .. шийдвэрийг байршуулаагүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 84.6 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ...” заасны дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж ажиллаагүй, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан тул нягтлан бодогчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Цалингийн зардлаас илүү шилжүүлсэн 1.3 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварын тооцооноос газрын төлбөрийн 578.5 мянган төгрөгийг төлсөн” зөрчилд зөвлөмж, Шилэн дансанд мэдээлэл дутуу байршуулж, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан тул сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөгдсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|-----------------|----------|--------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 90,340.9 | | | 0% |
| Зөвлөмж | 1 | 578.5 | 1 | 578.5 | 100% |
| Нийт дүн | 1 | 90,919.4 | 1 | 578.5 | 50% |

Тайлант оны аудитаар өмнөх оны шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгахад хэрэгжилт 50 хувийн гүйцэтгэлтэй ба Шилэн дансанд өр үүсгэсэн 38.1 сая төгрөгийн өр үүсгэсэн шийдвэрийг байршуулаагүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 84.6 хувьтай, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна:

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Алтай сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтлөөгүй, аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан асуудлыг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 79.8 сая төгрөгийн алдаа¹ илэрч аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд ХХОАТ-ын 3.8 сая төгрөгийн авлагыг дутуу тусгасан.
2. Санхүүгийн байдлын тайланд бараа үйлчилгээний зардлын өр төлбөрийг 5.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
3. Санхүүгийн байдлын тайланд машин тоног төхөөрөмжийн 26.8 сая төгрөгийн элэгдлийг дутуу тусгасан.
4. Санхүүгийн байдлын тайланд тавилга, аж ахуйн эд хогшлын 0.2 сая төгрөгийн элэгдлийг илүү тусгасан.
5. Үнэ төлбөргүй авсан 160.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод аваагүй, үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийг дутуу тайлагнасан.
6. Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 3.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан.
7. Тайлант оны үр дүнг 138.0 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
8. Мөнгөн гүйлгээний тайланд цалингийн зардлыг 0.7 сая төгрөгөөр илүү тайлагнасан.
9. Мөнгөн гүйлгээний тайланд цалингийн зардлыг 3.7 сая төгрөгөөр илүү тайлагнасан.
10. Төсвийн гүйцэтгэлийн тайланг 11.9 сая төгрөгөөр алдаатай илэрхийлсэн.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар 210.7 сая төгрөгийн зөрчил² илэрч 5.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 164.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 38.2 сая төгрөгийн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 2.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитын дүнгээр 5.2 сая төгрөгийн зөрчилд 2 ш төлбөрийн акт тогтоов.

1. Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын тооцоогоор 6 албан хаагчид 43.2 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо 4.3 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно”, 6.1.19-д “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг”, 28 дугаар зүйлийн 28.7-д “Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.”,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна”, 7.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 21-р зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,..... тооцон албан татвар ногдуулна”, 25 дугаар зүйлийн 25.1-д “Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална”, 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

2. Албан хаагчдад олгосон урьдчилгааны тооцооноос 0.9 сая төгрөгийг дутуу суутгаж, санхүүгийн тайланд авлагаар тусгаж тайлагнаагүй орхигдуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар 202.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгөв.Үүнд:

1. Байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого, бүртгэл, хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, 160.8 сая төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг орлогод аваагүй, нярав нь 3.9 сая төгрөгийн бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, аж ахуйн материалын орлого, зарцуулалтын тайланг гаргаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох

бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Байгууллагын хөрөнгө, бараа материалын тооллогыг чанартай, иж бүрэн, үнэн зөв хийж, үр дүнг дэлгэрэнгүй, бодитой тайлагнах, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж байгууллагын аж ахуй бараа материал, хөрөнгийн бүртгэл тооцоог сайжруулах талаар албан шаардлага өгөв.

2. Шилэн дансанд өр үүсгэсэн 38.1 сая төгрөгийн өр үүсгэсэн шийдвэрийг байршуулаагүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 84.6 хувьтай байна. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан ба мэдээлсэн байдлын хэрэгжилт 84.6 хувь байгааг харгалзаж сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгч дараа оны аудитаар зөрчлийг давтан гаргасан тохиолдолд дараагийн шатны арга хэмжээ авах талаар анхааруулав..

5.3 Зөвлөмж

Аудитаар 2.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

Сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Б/06 дугаар захирамжаар засаг даргын зөвлөхийн орон тоо бий болгож, төсвөөс цалингийн зардалд 2.5 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно”, 5.4-т “Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, батлагдсан бүтэц орон тооны хязгаарыг баримталж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах;

Дээрх зөвлөмж болон бусад шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|-----------|-----------------------------------|-----------|--------------------------|-----------|------------|-----------|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ХХОАТ-ын авлагыг дутуу тусгасан | 1 | 3865.7 | 1 | 3865.7 | | | 1 | 3865.7 | | | | |
| Санхүүгийн байдлын тайланд бараа үйлчилгээний зардлын өр төлбөрийг дутуу тайлагнасан | 1 | 5924.0 | 1 | 5924.0 | | | 1 | 5924.0 | | | | |
| Машин тоног төхөөрөмжийн элэгдлийг санхүүгийн тайланд дутуу тусгасан | 1 | 26,827.0 | | | 1 | 26,827.0 | 1 | 26,827.0 | | | | |
| Тавилга, аж ахуйн эд хогшлын элэгдлийг тайланд илүү тусгасан | 1 | 180.6 | | | 1 | 180.6 | 1 | 180.6 | | | | |
| Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 3.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан | 1 | 3,865.7 | | | 1 | 3,865.7 | 1 | 3,865.7 | | | | |
| Үнэ төлбөргүй авсан 160.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод аваагүй | 1 | 160,808.0 | 1 | 160,808.0 | | | 1 | 160,808.0 | | | | |
| Тайлант оны үр дүнг дутуу тайлагнасан. | 1 | 138,027.3 | | | 1 | 138,027.3 | 1 | 138,027.3 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд | 1 | 711.0 | | | 1 | 711.0 | 1 | 711.0 | | | | |

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | | | | | | | | |
|--|-----------|------------------|----------|------------------|----------|------------------|-----------|------------------|--|--|--|--|
| цалингийн зардлыг илүү тайлагнасан. | | | | | | | | | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд НДС-ийн зардлыг дутуу тайлагнасан. | 1 | 3702.4 | | | 1 | 3702.4 | 1 | 3702.4 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг алдаатай илэрхийлсэн. | 1 | 11,919.9 | | | 1 | 11,919.9 | 1 | 11,919.9 | | | | |
| Дүн | 10 | 355,830.9 | 3 | 170,597.7 | 7 | 185,233.2 | 10 | 355,830.9 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|------------------|---------------|----------------|-----------------|------------------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Олгосон мөнгөн урамшууллаас ХХОАТ суутгаагүй. | 1 | 4,321.4 | 1 | 4,321.4 | | | | | | | | |
| Албан хаагчдад олгосон урьдчилгааг дутуу суутгасан. | 1 | 900.0 | 1 | 900.0 | | | | | | | | |
| Байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого, бүртгэл, хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, тайлант онд 3.9 сая төгрөгийн бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, аж ахуйн материалын орлого ба зарцуулалтын тайланг гаргаагүй. | 1 | 164,707.0 | | | 1 | 164,707.0 | | | | | | |
| Шилэн дансанд өр үүсгэсэн 38.1 сая төгрөгийн өр үүсгэсэн шийдвэрийг байршуулаагүй, өмнөх оны зөрчлийг давтан гаргасан | 1 | 38,154.7 | | | | | | | 1 | 38,154.7 | | |
| Дүн | 4 | 208,083.1 | 2 | 5,221.4 | 1 | 164,707.0 | | | 1 | 38,154.7 | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | |
|--------------------|-------------|---------------|-----------------|---------|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж |
| | | | | |

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|---|----------|----------------|-----|-----|-----|-----|----------|----------------|
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Засаг даргын зөвлөхийн орон тоо бий болгож, 2.5 сая төгрөгийн төсвийг үргүй зарцуулсан. | 1 | 2,571.3 | | | | | 1 | 2,571.3 |
| Дүн | 1 | 2,571.3 | | | | | 1 | 2,571.3 |
| Нийт дүн | 1 | 2,571.3 | | | | | 1 | 2,571.3 |